



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/15

Номгон

Аймгийн Хил хамгаалах туслах хүчний  
2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Хилийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хил хамгаалах туслах хүчний 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

624010178

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орны дүгээр сарын 01-ны өдрийн 01 дугаар захирамжийн хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ  
ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Зорилго:** Монгол Улсын хилийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149 дүгээр зарлигаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, хилчид, ард иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх, улсын хил орчмын нутаг дэвсгэрт хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад оршино.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв сая, төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
<b>Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:</b>							
1	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг удирдлагаар хангах	-	Зөвлөлийн ажлыг удирдлагаар хангасан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -45%	2024.01.10 2024.12.25	ХХТХЗ-ийн дарга, Нарийн бичгийн дарга
2	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн ажлыг зөвлөлийн даргад танилцуулж, үр дүнг тооцох	-	Зөвлөлийн ажлыг Засаг даргад танилцуулж, үр дүнг тооцох	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.03.01 2024.12.25	Нарийн бичгийн дарга, Хууль, эрх зүйн хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги
3	Хилийн бүсэд ажил, үйлдвэрлэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулж, удирдах	-	туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг удирдан зохион байгуулсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	Хууль, эрх зүйн хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги

1	2	3	4	5	6	7	8
4	Улсын хил хамгаалалтад төсөвлөсөн нэмэгдэл зардлыг сумын төсөвт тусгах, хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	-	Нэмэгдэл зардалыг сумын төсөвт тусгах, хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.06.01 2024.12.30	Нарийн бичгийн дарга Санхүү, төрийн сангийн хэлтэс
5	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлгөөн, гишүүдийн цугларалтыг зохион байгуулах	5.000.000	Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн цугларалтыг зохион байгуулсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.06.01 2024.11.30	Зөвлөлийн дарга, Хилийн цэргийн 0166 дугаар анги
6	Хил хамгаалах туслах хүчний гишүүнээр элсэх хүсэлт гаргасан иргэдийг судалж, туслах хүчний бүрэлдэхүүнд оруулж, гэрээ байгуулж ажиллах	-	Хил хамгаалах туслах хүчний гишүүнээр элсэх хүсэлт гаргасан иргэдийг судалж гэрээ байгуулсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.03.01 2024.12.25	Нарийн бичгийн дарга Хууль, эрх зүйн хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги
7	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг улс хил, хилийн багана, хилчдийн ахуй нөхцөлтэй танилцах нэг өдрийн аялал зохион байгуулах	3.000.000	Сурагчдыг улс хил, хилийн багана, хилчдийн ахуй нөхцөлтэй танилцуулах нэг өдрийн аялал зохион байгуулсан байна.	1	Сүүлийн хагас жил -100%	2024.06.01 2024.09.30	Нийгмийн бодлогын хэлтэс Хууль, эрх зүйн хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги
8	Хил хамгаалалтад туслах хүчний гишүүд, сумын ард иргэдэд урлаг соёлоор үйлчилэх	-	Хил хамгаалалтад туслах хүчний гишүүд, сумын ард иргэдийн дунд урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж үйлчилсэн байна.	-	Сүүлийн хагас жил -100%	2024.08.01 2024.08.30	Хилийн цэргийн 0166 дугаар анги Сумын ХХТХЗ
<b>Хоёр.Хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах чиглэлээр:</b>							
9	Хилийн цэргийн 0203, 0112 дугаар салбар (Хатансуудал,	57.000.000	Дархан цаазат газар орныг хянах 10	-	Эхний хагас жил -100%	2024.02.01 2024.02.29	Хилийн цэргийн 0166 дугаар анги

1	2	3	4	5	6	7	8
	Цагаанбогд)-ын хариуцсан хилийн хэсэг, дархан цаазат газар орныг хянах 10 ширхэг теле камер суурилуулж ашиглах		ширхэг теле камер суурилуулсан байх				
10	Хилийн цэргийн 0203, 0112 дугаар салбар (Хатансуудал, Цагаанбогд)-ын хариуцсан хэсэг, дархан цаазат газар оронд ашиглах 4 ширхэг нисэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) худалдан авах	43.920.000	Дархан цаазат газар оронд ашиглах 4 ширхэг нисэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) худалдан авах	-	Эхний хагас жил -100%	2024.03.01 2024.03.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги
<b>Гурав.Нийгмийн асуудлыг дээшлүүлэх чиглэлээр:</b>							
11	Төсөл, хөтөлбөрт хилчид, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг хамруулах	-	Төсөл, хөтөлбөрт хилчид, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг хамруулсан байна.	-	Сүүлийн хагас жил -100%	2024.01.15 2024.12.25	Нарийн бичгийн дарга, Хууль, эрх зүйн хэлтэс Нийгмийн бодлогын хэлтэс
12	Хил хамгаалалтад туслах хүчний гишүүн 2 өрхөд "Халуун сэтгэл-дэм" аян зохион байгуулах	-	"Халуун сэтгэл-дэм" аян зохион байгуулсан байна.	-	Сүүлийн хагас жил -100%	2024.02.01 2024.07.30	Хилийн цэргийн 0166 дугаар анги
13	Хилийн цэргийн салбарын хилчид, туслах хүчний гишүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэхийн үзлэгт хамруулах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх, эрүүл мэндийн зөвлөмж өгөх	-	Хилчид, туслах хүчний гишүүдийг урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэхийн үзлэгт хамруулах, эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээг цаг тухайд нь үзүүлэх, эрүүл мэндийн зөвлөмж өгсөн байна.		Сүүлийн хагас жил -100%	2024.03.01 2024.10.30	Эрүүл мэндийн газар Хилийн цэргийн 0166 дугаар анги Сумын ХХТХЗ
14	Хилийн цэргийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын барилга байгууламжид их засвар хийх	-	барилга байгууламжид их засвар хийх хөрөнгийг улсын		Эхний хагас жил -100%	2024.02.01 2024.02.29	Зөвлөлийн дарга, Санхүү, төрийн сангийн хэлтэс

1	2	3	4	5	6	7	8
	хөрөнгийг улсын төсөвт суулгах ажилд дэмжлэг үзүүлэх		төсөвт суулгах ажилд дэмжлэг үзүүлэх				
15	Улсын хил хамгаалалтад үр бүтээлтэй ажилласан, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг удаа дараа илрүүлсэн, хилийн болон нийгмийн хэв журам, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц үнэтэй мэдээлэл өгсөн туслах хүчний гишүүнийг байгууллагын шагналд тодорхойлох	-	хилийн болон нийгмийн хэв журам, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдалд нөлөөлөхүйц үнэтэй мэдээлэл өгсөн туслах хүчний гишүүнийг байгууллагын шагналд тодорхойл ажилд хамтран оролцох	-	Эхний хагас жил -100%	2024.06.01 2024.06.29	Хилийн цэргийн 0166 дугаар анги Хууль, эрх зүйн хэлтэс Цагдаагийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар
16	Туслах хүчний гишүүдийг хил хамгаалалтад оролцуулж, үүрэг гүйцэтгэлтийг дүгнэж, урамшуулах	-	Туслах хүчний гишүүдийг хил хамгаалалтад оролцуулж, үүрэг гүйцэтгэлтийг дүгнэж, урамшуулсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.03.01 2024.12.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги Хууль зүйн хэлтэс Сумын ХХТХЗ
17	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй түншлэлийн харилцаа тогтоож, хамтран ажиллах	-	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй түншлэлийн харилцаа тогтоож, хамтран ажилласан байна	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс Хууль зүйн хэлтэс Нийгмийн бодлогын хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги
<b>Дөрөв. Хяналт шалгалтын ажлын чиглэлээр:</b>							
18	Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг шалгах,	-	Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж,	-	Эхний хагас жил 50%	2024.01.10 2024.11.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги,

1	2	3	4	5	6	7	8
	хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай арга хэмжээ авах		иргэдийн үйл ажиллагааг шалгах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулсан байна.		Сүүлийн хагас жил -50%		Нарийн бичгийн дарга, Цагдаагийн тасаг, Хилийн тагнуулын тасаг
19	Хилийн бүсэд айл өрхийг нутаглуулах ажлыг зохион байгуулах, айл өрх, малын тоо, нутаглах газар орон, малын им, тамганы судалгааг гаргах	-	Хилийн бүсэд айл өрхийг нутаглуулах ажлыг зохион байгуулах, айл өрх, малын тоо, нутаглах газар орон, малын им, тамганы судалгааг гаргасан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.10.25	Хүнс, хөдөө аж ахуйн газар Сумын ХХТХЗ хилийн цэргийн 0166 дугаар анги
20	Улсын хил хамгаалалтад төлөвлөсөн зардлын зарцуулалтад хяналт тавих, зарцуулалтын тайланг нэгтгэн гаргаж, туслах хүчний зөвлөлд тайлагнах	-	Улсын хил хамгаалалтад төлөвлөсөн зардлын зарцуулалтыг тайлагнасан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.06.01 2024.11.25	Хууль, эрх зүйн хэлтэс Хилийн цэргийн 0166 дугаар анги
<b>Тав. Мэдээ мэдээлэлийн чиглэлээр:</b>							
21	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилах	-	Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байна.	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.10.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги Хууль, эрх зүйн хэлтэс Сумын ХХТХЗ
22	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг хил орчмын ард иргэд, туслах хүчний гишүүдэд мэдээлэх, зөвлөмж хүргэх	-	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг хил орчмын ард иргэд, туслах хүчний гишүүдэд мэдээлж зөвлөмж хүргэсэн байна.	-	Эхний хагас жил 100% Сүүлийн хагас жил -100%	2024.01.10 2024.12.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги Онцгой байдлын газар Сумын ХХТХЗ

1	2	3	4	5	6	7	8
23	Зөвлөлийн гишүүдийг хилийн нөхцөл байдал, туслах хүчний зөвлөлийн ажил, шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах	-	Туслах хүчний зөвлөлийн ажилд шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах	-	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил -50%	2024.01.10 2024.12.25	Хилийн цэргийн 0166 дугаар анги

\_\_\_\_\_оо\_\_\_\_\_